

2019 ОНЫ 2 САР

АРГА ЗҮЙ

Татварын ерөнхий хуулийн төслийн хэлэлцүүлэг (i) татварын эрх зүйн шинэчлэлийн бодлого, (ii) татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга гэсэн хоёр үндсэн хэсгээр болсон ба эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл оролцон санал бодлоо илэрхийлж хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хэлэлцүүлэг дараах арга зүйгээр явагдав:

- *Татварын шинэчлэлийн бодлогын талаарх судлаачдын байр суурь, мэдээллийг сонсох.*
- *Татварын шинэчлэлийн хүрээнд анхаарах асуудлыг оролцогчид хөндөн ярилцаж, татварын бодлого, практик хэрэгжилтээс хамаарч хувийн хэвшилд тулгарч байгаа асуудлыг хэлэлцэх.*
- *Хэлэлцүүлэгт үндэслэн иргэний нийгмийн байгууллагууд хуулийн төсөлд тодорхой санал гаргаж холбогдох талууд болон олон нийтэд хүргэх.*

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ХУРААНГУЙ

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д 2018 оны 5 дугаар сард өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан Нээлттэй Нийгэм Форум уг хуулийн төслөөр хувийн хэвшил, төрийн бус байгууллага, хуульчид, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан билээ.

Хэлэлцүүлгийн эхэнд Санхүү эдийн засгийн дээд сургуулийн багш нар өөрсдийн судалгаанд тулгуурлан татварын шинэчлэлийн бодлогын талаар товч мэдээлэл хийж, оролцогчид өнөөдөр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх оролдлогыг хуулийн төсөлд тусгасан эсэхийг нягтлан хэлэлцэв. Түүнчлэн, татварын шинэчлэлийн хүрээнд хувь хүн, аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийн татвартай холбогдох шаардлагатай шинэчлэлийн талаар хэлэлцэж, Татварын ерөнхий хуулийн төсөлд хамаарах тодорхой саналууд гаргалаа.

Оролцогчдын мэдлэг, туршлага, тэдэнд тулгарч буй хүндрэл бэрхшээлд тулгуурлан хэлэлцүүлэг өрнөсөн тул хуулийн төслийн цогц шинжилгээ гэхээс илүүтэй энэ чиглэлээр анхаарвал зохих зарим асуудлыг тодорхойлохыг зорьсон болно.

Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж

1. Гарааны буюу анх бизнес эрхлэгчдэд бизнесээ эхлүүлэх, бойжих боломжийг татварын бодлогоор олгоход тодорхой ахиц гаргах;
2. Хөнгөлөлт, чөлөөлөлт нь авлига цэцэглэх үндэс суурийг бүрдүүлдэг тул хуулийн төслөөс хасах, үүний оронд татвар төлөгчдийн ялгаатай байдалд тулгуурласан уян хатан бодлого хэрэгжүүлэх;
3. Татварын бааз сууриа өргөтгөх бодлогыг хуулийн төсөлд тусгах;
4. Хувь хүний орлогын албан татварт үзүүлж байгаа хөнгөлөлтийг жилийн эцэст татварын тайлангаа ирүүлсний дараа үзүүлдэг болох;
5. Татварын ерөнхий хуулийн төслийн бүтцийг эргэн харж, логик уялдаа холбоог сайжруулах, татварын албаны бүтэц, удирдлага, бүрэн эрхийг тодорхой болгож, ойлгомжтойгоор хуульд тусгах, мөн удирдлагад тавих шаардлагыг хуульчлах.

САНАЛ СОЛИЛЦСОН АСУУДАЛ

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

Гарааны буюу анхлан бизнес эрхлэгчдэд бизнесээ эхлүүлэх, бойжих боломжийг татварын бодлогоор олгох шаардлагатай байгаа бөгөөд гаднын улс орнуудын туршлагыг судалж, авууштай сайн туршлагыг холбогдох хуульд тусгах шаардлагатай байна. Тухайлбал, анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа татвар авах, мөн татвар хурааж эхлэх хугацааг салбарын онцлогт тохируулан өөр өөрөөр тодорхойлж болох юм.

Нэгэнт бүртгэлтэй татвар төлөгчдөд чиглэсэн бодлогоос илүүтэй татварын бааз сууриа өргөтгөхөд анхаарах шаардлагатай. Тухайлбал, малын хөлийн татвар авахгүй байгаа нь байгаль орчинд ээлгүйн зэрэгцээ, мөнгө угаах, авлигын гэмт хэрэгт таатай хөрс суурь болж байна. Татвар авахгүйгээс үүдэн нэг мал доод тал нь хоёр, гурав тоологдож, малын тоо толгойг буруу гаргаж байгаа нь банкиг ч эрсдэлд оруулж байна.

Мөн түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн албан татварт өөрчлөлт оруулж, гурван жил тутамд байршил, зориулалтаас нь хамааруулан жишиг үнэ тогтоох шаардлагатай юм. Энэ хүрээнд орон сууц эзэмшиж байгаа хүнд тодорхой тооны босго тавьж, үүнээс илүү тооны орон сууцанд татвар ногдуулах нь зүйтэй. Учир нь одоогийн үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулиар “орон сууц эзэмшигч” татвар төлөхгүй байгаа нь хэдэн арван орон сууц эзэмшиж байгаа хүнд давуу байдлыг олгож байна.

Эмнэлэг, хувийн сургууль, цэцэрлэг, сүм хийд, шашны байгууллагуудыг тооцоо

судалгааны үндсэн дээр тодорхой хувиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-т хамруулах шаардлагатай. Тухайлбал, гоо сайхны хагалгаа, эмчилгээ хийж байгаа үйл ажиллагаанд татвар ногдуулах боломжтой. Мөн эдгээр байгууллагаас ашгийн татвар авч, ингэхдээ татвар авах хувийг 10-аас бага хувиар тогтоож өгч болох юм.

Монгол Улсад тодорхой зах зээлээ хангаж байсан хөнгөн үйлдвэрлэлийн салбар бараг дампуурч байгаа нь “гаальтай машин” гэх бараа, түүхий эдийг гаальд мэдүүлж, татвар төлөхгүйгээр шударга бусаар бараа импортлогчидтой холбоотой. Татваргүйгээр бараа түүхий эд импортлогчидтой шударга татвар төлөгчид үнээр өрсөлдөх боломжгүй тул энэ нь татвар төлөгчдөд маш их дарамт учруулж байна. Үүний зэрэгцээ олон улсын конвенцын дагуу ямар ч татвар төлдөггүй төмөр зам асар их төлбөр хураамж, үйлчилгээний зардал авдгаас болж төмөр замаар бараа тээвэрлэх, буулгах, ачих үед төлсөн аливаа төлбөр нь хувийн хэвшлийг НӨАТ-ын дарамтад оруулж байна. Тиймээс хөнгөн үйлдвэрлэлийн салбараа өөд нь татахын тулд татвартай холбогдон үүсэж байгаа дээрх асуудлыг эргэж харах шаардлагатай.

Мэргэжлийн урлагийн үйлчилгээ үзүүлэгч хувийн өмчийн байгууллага үзвэр үйлчилгээний үнээс НӨАТ төлдөг бол төрийн өмчийн энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага НӨАТ төлдөггүй тул билетийн үнийн хувьд зөрүү үүсгэдэг. Тиймээс үзүүлж байгаа үйлчилгээний төрлөөр нь адилтган үзэж хувийн хэвшлийн мэргэжлийн урлагийн байгууллагыг НӨАТ-аас чөлөөлөх нь зүйтэй.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд татварын баазыг өргөтгөх тал дээр ахиц дэвшил харагдахгүй, харин бүртгэгдсэн татвар төлөгчдөөс татвараа хураах талд илүү зохицуулалтууд тусгагджээ.

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг сар бүр тооцон өгч байгааг өөрчилж татварын тайлангаа жилийн тодорхой улиралд тайлагнах, ийнхүү тайлагнасных нь дараа тохирох хөнгөлөлтийг буцаан олгодог тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай байна. Ийнхүү тайлагнахдаа гэр бүлээрээ, бие даан тайлагнах боломжийг нээж өгвөл тухайн гэр бүлийн орлого олж байгаа, тэжээлгэж байгаа хүний талаарх мэдээллийг бодитоор харах боломжтой болох юм. Энэ нь татвар төлөгчид хариуцлагатайгаар татвараа тайлагнах, иргэд эдийн засгийн боловсролоо дээшлүүлэх, өрхийн төсвөө хянахад суралцах зэрэг олон талын ач холбогдолтой.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТУХАЙД

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь бизнес эрхлэгчдэд төрийн байгууллагад авлигал өгөх үндэс болж байна. Тиймээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг байхгүй болгож, харин үүний оронд татвар төлөгчдийн олж буй орлого, гарааны бизнес зэрэгт тохирох татварын бодлогоор дэмжих нь зүйтэй.

Өнөөгийн практикт татварын алба нь татвар төлөгчийн баазаа өргөтгөхөд бага анхаарч, харин нэгэнт бүртгэлтэй татвар төлөгчдөө дарамтлах чиглэлээр ажиллаж байна гэсэн

шүүмжлэл их өрнөдөг. Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд татварын баазыг өргөтгөх тал дээр ахиц дэвшил харагдахгүй, харин бүртгэгдсэн татвар төлөгчдөөс татвараа хураах талд илүү зохицуулалтууд тусгагджээ гэж оролцогчид дүгнэлээ.

Иргэн, аж ахуйн нэгж, ялангуяа шинээр бий болсон аж ахуйн нэгжид чиглэсэн татварын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх соён гэгээрүүлэх ажлыг хийх шаардлагатай бөгөөд энэ үүргийг хуульд тодорхой тусгах нь зүйтэй. Практикт татварын байцаагч зөвлөн туслах гэхээс илүүтэй, татвараа авахыг чухалчлан үздэг. Тиймээс татварын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх тусгай албатай байх, үгүй бол нээлттэй сонгон шалгаруулалтаар иргэний нийгмийн байгууллагад энэ чиг үүргээ шилжүүлэх талаарх зохицуулалтыг хуульд тусгах нь татвараа цаг тухайд нь төлдөг хариуцлагатай татвар төлөгчдийг бий болгох, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх чухал гарц билээ. Тиймээс хуулийн төслийн 76 дугаар зүйлийн 76.3-т ...сургалт... хариуцсан харьяа нэгжтэй байж болно гэснийг нэгжтэй байна хэмээн өөрчилж, хариуцах чиг үүргийг тодорхой болгох нь зүйтэй.

Татварын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх тусгай албатай байх, үгүй бол нээлттэй сонгон шалгаруулалтаар иргэний нийгмийн байгууллагад энэ чиг үүргээ шилжүүлэх талаарх зохицуулалтыг хуульд тусгах нь татвараа цаг тухайд нь төлдөг хариуцлагатай татвар төлөгчдийг бий болгох, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх чухал гарц болно.

Хуулийн төсөлд ижил утга агуулгатай зүйл, заалт байхын зэрэгцээ, нэг дор оруулбал ойлгомжтой байх зохицуулалтыг хэд хэдэн бүлэгт салгаж оруулсан зэрэг нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж болзошгүй юм. Тухайлбал, хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 40.12.2 дахь заалт ижил байна. Мөн түүнчлэн 5 дугаар зүйлд татварын зарчим хэмээн тусгаж, 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалтад татварын албаны зарчим хэмээн оруулсан нь ойлгомжгүй байна. Энэ мэтээр шүүж үзэх замаар хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн сайжруулах шаардлагатай.

Маргаан таслах зөвлөлд хандан гомдол гаргах бол ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувь, дээд хэмжээ нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй хэмээн заажээ. Хуулийн төслийн 5 дугаар зүйлд заасан татварын зарчимд туссан татвар төлөгчийг ялгаварлахгүй байх зарчим энд алдагдаж байна. Тухайлбал, энэ заалт дөнгөж гарааны бизнес эрхэлж байгаа эсхүл бэсрэг, жижиг татвар төлөгчдөд хүндээр тусахаар байгаа бол том татвар төлөгчдөд зөөлөн ханджээ.

Татварын алба, татварын байцаагчийн хийх үйл ажиллагааг бүлэг тус бүрд салгаж оруулсан нь татвар төлөгчдөд ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсгэхээр байна. Мөн татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дэд

даргад тавих шаардлагыг хуульд тусгаагүй байна. Үүний зэрэгцээ хуулийн төсөлд татварын албаны удирдлагад дэд дарга байхаар тусгаагүй атал, 79 дүгээр зүйлийн 79.9 дэх заалтад даргын эзгүйд дэд дарга орлоно хэмээн заажээ. Энэ нь татвар төлөгчдийг төөрөгдүүлж, улмаар хуулийн хэрэгжилтийн шатанд хүндрэл учруулахаар байна. Татварын албаны удирдлагад тавих шаардлагыг хуульд нарийвчлан зааж өгөх нь төрийн албаны “чадахуйн зарчим”-ыг хэрэгжүүлэх чухал нөхцөл мөн. “Татвар хураагч” гэх шинэ ойлголтыг хуулийн төсөлд тусгасныг хасах шаардлагатай. Ямар ч бүрэн эрхгүй, татварын байцаагч болохын өмнөх дамжлага маягийн орон тоог хуульчилсан нь зохисгүй байна.

Дээрхтэй адил тодорхойгүй байдал нь Эрсдэлийн удирдлагын хороог байгуулах, гишүүдэд ямар шаардлага тавих тухай асуудал юм. Зөвхөн нэг гишүүн нь санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас орохоор заажээ. Бусад гишүүнийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө гэснээс өөр тодорхой зохицуулалт байхгүй байна. Гэтэл тус хорооны хэлэлцэж, батлуулсан эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний үр дүнг үндэслэн татварын хяналт, шалгалтад хамруулах, татвар төлөгчийг тодорхойлох юм. Ер нь Татварын ерөнхий хуулийн төсөлд туссан Зөвлөл, Хороо зэрэг бүтцийг хэрхэн байгуулах, бүрэн эрхийн хугацаа, гишүүнд тавигдах шаардлага зэргийг харилцан адилгүй зохицуулсан нь тодорхой бус байдлыг бий болгожээ. Дээр дурдсан Эрсдэлийн удирдлагын хорооны тухайд гишүүд хэн байх, хэдэн гишүүнтэй байх нь ч тодорхойгүй бол Маргаан таслах зөвлөлийн хувьд нэлээд тодорхой туссан ч гишүүнээр томилогдсоноос хойш хэдий хугацаанд

ажиллах, хугацаанаас өмнө чөлөөлөх үндэслэл юу болох зэргийг тодорхойлоогүй байна. Энэ нь томилж чөлөөлөх эрх бүхий этгээдийн шийдэх асуудал болжээ. Гэтэл эдгээр байгууллага сонирхлын зөрчилгүй, хараат бус байх нь татвар төлөгчийн эрх ашиг сонирхолд нийцнэ.

Үүний зэрэгцээ хуулийн төслийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтад Маргаан таслах зөвлөлд хандан гомдол гаргах бол ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувь, дээд хэмжээ нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй хэмээн заажээ. Хуулийн төслийн 5 дугаар зүйлд заасан татварын зарчимд туссан татвар төлөгчийг ялгаварлахгүй байх зарчим алдагдаж байна. Тухайлбал, дөнгөж гарааны бизнес эрхэлж байгаа эсхүл бэсрэг, жижиг татвар төлөгчид хүндээр тусахаар байгаа бол том татвар төлөгчид зөөлөн ханджээ. Тухайлбал, Татварын алба Оюутолгой ХХК-д 155 сая ам.доллар (390 гаруй тэрбум)-ын татварын торгууль ногдуулсан бөгөөд энэ дүнг хүлээн зөвшөөрөхгүй гэж тус компани маргах бол үнийн дүнгийн 10 хувь 40 орчим тэрбумыг төлөх ёстой байтал дээд үнийн дүнгээр төлөх юм бол маргаж байгаа дүнгийн 0.02 хувийг л төлөхөөр байна. Төрөөс бэсрэг, жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжих бодлого барина гэдэг ч энэ хуулийн төсөлд дэмжих биш, харин эсрэгээр нь илүү хүнд байдалд оруулахаар байна. Нөгөө талаас, төсөвт төлсөн дүнг хэрхэх нь тодорхойгүй байна.

Хуулийн төслийн 30 дугаар зүйлд татварын тайланд залруулга хийхээр зохицуулсан нь татвар төлөгчдөд боломж олгосон хэмээн хууль санаачлагч үзэж байгаа хэдий ч 30 дугаар зүйлийн 30.6 дахь заалтад татварын ногдлыг бууруулах залруулга нь өмнө тооцсон алдангийн хэмжээг өөрчлөх үндэслэл болохгүй гэжээ. Энэ нь татвар төлөгчийн эрхийг дордуулж байна. Мөн

алданги тооцох зарчим нь Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд туссан татварын алба, татвар төлөгчийн эрх, үүргийн тэнцвэрийг хангана гэсэн зорилттой зөрчилдөж байна. Тухайлбал, татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээ Монгол Банкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байх бол, татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алданги тус зээлийн хүүгийн жигнэсэн дундаж байна гэжээ.

Хуулийн төсөлд алданги тооцох зарчим нь Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд туссан татварын алба, татвар төлөгчийн эрх, үүргийн тэнцвэрийг хангана гэсэн зорилттой зөрчилдөж байна. Тухайлбал, татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээ Монгол Банкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байх бол, татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алданги тус зээлийн хүүгийн жигнэсэн дундаж байна гэжээ.

Түүнчлэн 46 дугаар зүйлийн 46.15 дахь заалтад магадлагч татварын улсын байцаагчийн шаардсан нотлох баримтыг ирүүлээгүй тохиолдолд ирүүлсэн нотлох баримтын хүрээнд шийдвэрлэхээр заасан нь захиргааны байгууллага өөрийнхөө

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧИД

Б.БАТТОГТОХ
Митчелл сан
Ж.ДЭЛГЭРСАЙХАН
СЭЗИС-ийн санхүүгийн
тэнхимийн профессор
М.ЖАРГАЛМАА
Төмөр трейд ХХК
С.МӨНХБААТАР
Татварт иргэний хяналт ТББ
Б.МЯГМАРСҮРЭН
ТТЭАХН ТББ
Д.ОРГИЛ
Бодь даатгал
Ч.ӨНӨРЖАРГАЛ
СЭЗИС-ийн нягтлан бодох
тэнхимийн ахлах багш
Х.ПҮРЭВБАДАМ
Монголын Үндэсний Цирк ХХК
Ж.САЙНЗАЯА
Үнэн хатамж ТББ
Д.САРАНТУЯА
Татварт иргэний хяналт ТББ
А.САРУУЛ
Монголын хуульчдын холбоо
С.ЦЭРЭНПҮРЭВ
Захиргааны шинэ санаачилга
ТББ

цуглуулж чадах нотлох баримтыг гомдол гаргагч гаргаж өгөөгүй гэх үндэслэлээр үнэлэхгүй байх боломжтой болж байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.43 дахь заалтад гадаад улсад сурдаг, ажилладаг, аялж байгаа гэх мэт шалтгааныг нэмж оруулах нь зүйтэй.

Татварын улсын байцаагч, хураагчийн үйлдсэн зөрчлийн улмаас татвар төлөгчид учирсан хохирлыг гэм буруутай албан хаагч хариуцна гэсэн заалт нь татвар төлөгчийн эрх ашгийг бүрэн хамгаалах заалт биш юм. Төрийн нэрийн өмнөөс ажиллаж иргэнд хохирол учруулсан бол төр хохирлыг барагдуулж, буруутай этгээдээс төр нэхэмжлэх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Хуулийн төслийг ерөнхийд нь дүгнэвэл, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тал дээр ахиц гаргасан, шинэ зохицуулалтыг тусгасан сайн талтай байгаа хэдий ч татвар төлөгчийн эрх ашгийг дордуулсан, татварын алба татварын орлогоо хэрхэн, зовлон багатай, хурдан бүрдүүлэх вэ? гэдэгт илүүтэй чиглэсэн төсөл болжээ хэмээн үзэхээр байна.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРМ

ННФ-ын үйл ажиллагааны гол зорилго нь чанартай мэдээлэл, судалгаанд үндэслэсэн бодлогын үр нөлөөтэй, олон талын оролцоог хангасан өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих явдал юм.

ТАЛАРХАЛ

Татварын бодлого нь иргэн, аж ахуйн нэгжид шууд нөлөө үзүүлдэг тул энэ чиглэлээр өрнөж буй шинэчлэлийн үйл явцад оролцож, дуу хоолойгоо хүргэх нь чухал ач холбогдолтой. Тиймээс энэхүү чухал сэдвээр өрнөж буй хэлэлцүүлэгт цаг заваа гарган оролцсон нийт оролцогчдодоо талархал илэрхийлье. Түүнчлэн тодорхой сэдвээр танилцуулга тавьсан их дээд сургуулийн эрдэмтэн судлаачид, татварын бодлогод онцгой үүрэгтэй оролцдог хувийн хэвшлийн төлөөлөлд гүн талархал илэрхийлье.

Хурлын тэмдэглэлийг эцэслэн боловсруулсан Б.ХИШИГСАЙХАН
(ННФ-ын Эрхзүйн хөтөлбөрийн менежер)



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Жамьян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn